



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 27 өдөр

Дугаар А/269

Хэрлэн сум

Малчдыг дэмжих анхдугаар аян
өрнүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 34 дүгээр тогтоолоор баталсан “Монгол малчин” үндэсний хөтөлбөр, Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Малчдыг мэдээллээр хангах, хөгжүүлэх, өрхийн орлогыг нэмэгдүүлэх, тэдгээрийг чадавхжуулах зорилгоор “Малчдыг дэмжих анхдугаар аян”-ыг орон нутагтаа өрнүүлэхийг сумын Засаг дарга нарт даалгасугай.

2.Малчдыг дэмжих анхдугаар аяныг зохион байгуулах төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, тайланг 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Хүнс, Хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (Ж.Энх-Амгалан)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2023 оны
дугаар сарын 27-ны өдрийн
дугаар захирамжийн хавсралт

“МАЛЧДЫГ ДЭМЖИХ АНХДУГААР АЯН”-ЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

| Д/д | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Зарцуулах хөрөнгийн эх үүсвэр | Хэрэгжүүлэх байгууллага | Хүрэх түвшин, үр дүн |
|-----|--|------------------|--|-------------------------|---|
| 1 | Малчдын зөвөлгөөн зохион байгуулах. | 2023 | ОНХөгжлийн сан | Сумдын ЗДТГ, ХХААГазар | Малчдын зөвөлгөөн зохион байгуулсан байна. |
| 2 | Илгээлтийн эзэн аян өрнүүлэх. | 2023 | ОНХөгжлийн сан | Сумдын ЗДТГ, ХХААГазар | Үндэсний өв соёлыг түгээн дэлгэрүүлэх, малчин айлын өдөр тутмын ажилд тусалж нүүдлийн мал аж ахуйтай уялдаа холбоо бүхий малчин хүний давтагдашгүй соёлыг түгээн дэлгэрүүлж, сурталчлан таниулах ажлыг зохион байгуулсан байна. |
| 3 | Өрхийн аж ахуйд шаардлагатай бага оврын тоног төхөөрөмж болон борлуулалтын дэмжлэг үзүүлэх. | 2023 | ОНХөгжлийн сан | Сумдын ЗДТГ, ХХААГазар | Өрхийн аж ахуйд бага оврын тоног төхөөрөмжийн болон борлуулалтын дэмжлэг үзүүлсэн байна. |
| 4 | Орон нутгийг хөгжүүлэх арга хэмжээнд малчдын идэвх, оролцоог нэмэгдүүлж, тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, мал аж ахуйг тогтвортой эрхлэхийг дэмжин хөгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг хамтын оролцоогоор бүрдүүлэх. | 2023 | ОНХөгжлийн сан | Сумдын ЗДТГ | Мал аж ахуйг тогтвортой эрхлэхийг дэмжин хөгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг хамтын оролцоогоор бүрдүүлсэн байна. |
| 5 | Залуу малчдыг мэдлэгжүүлэх, мэдээллээр хангах, тэдгээрийн мэдлэг, туршлага, чадавхыг сайжруулах, хөгжүүлэх мал маллах уламжлалт соёлд сургахад ахмад малчдаас зөвлөх үйлчилгээг авах. | 2023 | ОНТөсөв, төсөл хөтөлбөр, Малын тоо толгойн албан татварын орлого | Сумдын ЗДТГ, ХХААГазар | Ахмад малчдын тэргүүн туршлага, уламжлалт мэдлэгийг мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр сурталчилан таниулсан байна. |
| 5 | Малын чанар, ашиг шимийг сайжруулж, өрхийн орлого, үр ашгийг | 2023 | ОНТөсөв, төсөл хөтөлбөр, | Сумдын ЗДТГ, ХХААГазар | Малчдын мэдлэг чадварыг дээшлүүлсэн байна. |

| | | | | | |
|---|---|------|--|--|--|
| | <p>өсгөх боломж, ач холбогдлыг малчид, туслах болон гэрээт малчид, мал бүхий иргэдэд таниулах ажлыг зохион байгуулах.</p> <p>Малчид, малчин өрхийн ахуйн соёлыг дээшлүүлэх, тэдгээрийн хэрэглээ, шаардлагад нийцсэн соёл урлагийн болон бусад ахуйн үйлчилгээг сайжруулах, малчдыг өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах, эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд хамрагдах ажлыг идэвхжүүлэх, ач холбогдлыг сурталчлах.</p> | | <p>Малын тоо толгойн албан татварын орлого</p> | <p>Сумдын ЗДТГ, Нийгмийн даатгалын газар, ХХААГазар, Эрүүл мэндийн газар</p> | <p>Малчдыг өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ, эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд хамрагдах ажлыг нэмэгдүүлсэн байна.</p> |
| 6 | | 2023 | <p>ОНТөсөв, төсөл хөтөлбөр, Малын тоо толгойн албан татварын орлого</p> | | <p>Малчин өрхийн орлогыг бууруулахгүйгээр бэлчээрийн даацаас хэтэрсэн малын тоог үе шаттай бууруулах, эдийн засгийн эргэлтэнд оруулах, бизнес маркетингийн мэдлэг чадвар эзэмшсэн байна.</p> |
| 7 | <p>Мал аж ахуйн бизнес маркетингийг хөгжүүлж малчдын хамтын хоршил, эко санаачилга, хөрөнгө оруулалтыг идэвхжүүлэх мэдлэг олгох.</p> | 2023 | <p>ОНТөсөв, Орон нутгийн хөгжлийн санд төвлөрсөн "Малын тоо толгойн албан татварын орлого"</p> | <p>Сумдын ЗДТГ, ХХААГазар</p> | <p>Аян амжилттай зохион байгуулсан сумыг шалгаруулсан байна.</p> |
| 8 | <p>Аяныг орон нутагт амжилттэй зохион байгуулсан сум шалгаруулах.</p> | 2023 | <p>ОНХөгжлийн сан</p> | <p>Сумдын ЗДТГ, ХХААГазар</p> | <p>MNS 6891:2020 "Хариуцлагатай нүүдэлчин зохистой дадлыг нэвтрүүлэхэд тавих шаардлага" стандартыг сурталчлан таниулсан байна.</p> |
| 9 | <p>Түүхий эдийн гарал үүсэл, мөшгөх системийг тогтворжуулах.</p> | 2023 | <p>ОНХөгжлийн сан</p> | <p>Сумдын ЗДТГ, ХХААГазар</p> | |